



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД Л.ХАЛТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2021.01.20 № 02.

Асуулт тавих тухай

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тохиолдол Монгол Улсад бүртгэгдсэн өдрөөс хойш халдварын тохиолдлын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж, улмаар цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн шат дараатай хариу арга хэмжээг Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс шуурхай авч хэрэгжүүлж байгаа хэдий ч зарим халдварын голомт хаанаас эхтэй, хэрхэн тархсан тухай олон тооны баталгаагүй мэдээллүүд хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд тархаад байна.

Тухайлбал, Эрүүл мэндийн яамнаас 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр коронавируст халдвар /КОВИД-19/-ын нөхцөл байдлын талаар мэдээлэл хийхдээ Дархан-Уул аймагт 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан Улаанбаатар төмөр замын “Дархан Өртөө” байгуулагдсаны 70 жилийн ойд зориулсан төмөр замчдын тэмцээн, уралдаан, соёлын арга хэмжээнд ОХУ-аас зарим иргэд ирж оролцсон гэх мэдээллийг хийсэн. Хэдийгээр Улаанбаатар төмөр зам ХНН-ээс дээрх мэдээллийг үгүйсгэсэн ч уг асуудал өнөөдрийг хүртэл эргэлзээтэй, олон нийтийн дунд төөрөгдөл үүсгэсэн хэвээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т заасныг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Дархан Өртөө” байгуулагдсаны 70 жилийн ойд зориулсан төмөр замчдын тэмцээн, уралдаан, соёлын үйл ажиллагаанд ОХУ-н 30 иргэн ирж оролцсон эсэх;
2. Хэрэв ОХУ-ын иргэд дээрх арга хэмжээнд оролцсон бол хэзээ, аль хилийн боомтоор, ямар шугамаар ирсэн тухай;
3. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын голомттой, дэгдэлт гарсан улс орноос ирсэн иргэдийг журмын дагуу тусгаарлан ажигласан эсэх зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ГАНХУЯГ

2020000082